



**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ
ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН
/Шинэчилсэн найруулга/
ТАНИЛЦУУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 06 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ



Анхны
хуулийг
баталсан

2000

НҮБ-ны загвар
хуульд үндэслэсэн
бие даасан хууль
батлагдсан

Шинэчилсэн
найруулга

2005

Худалдан авах
ажиллагааны
тогтолцоо
төвлөрсөн бус
тогтолцоонд
шилжсэн

Нэмэлт,
өөрчлөлт

2011

Худалдан авах
ажиллагааны
мэргэжлийн
байгууллага
байгуулсан

33 удаа
нэмэлт,
өөрчлөлт
орсон

2022*

2011, 2019, 2022
онуудад Сангийн яам
өөрчлөлт оруулсан.
16 удаагийн нэмэлт,
өөрчлөлт нь хуулийн
3, 34 дүгээр зүйлтэй
холбоотой

Хууль
/шинэчилсэн
найруулга/

2023

Хуулийн шинэчилсэн
найруулгын төслийг
УИХ 2023.06.16-ны
өдөр баталсан.
2024.01.01-ний өдрөөс
дагаж мөрдөнө.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ



Хүний оролцоог бууруулах

Цахим лавлагаа

- Тендер хянан үзэх шатыг цахим системээр гүйцэтгэнэ.
- Тендерт оролцогчийн бүртгэл үүсгэнэ.

Цахим дэлгүүр

Бараа, зөвлөхөөс бусад үйлчилгээг Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авна.




Нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх

Тендер шалгаруулалтын зарлал

- Зарлалыг цахим системд ил тод нийтэлнэ.
- Урилгыг цахим системд бүртгэлтэй компаниудад хүргүүлнэ.

Үнэлэх, гэрээ байгуулах мэдээлэл

- Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл нээлттэй байна.
- Шалгарсан компанийн мэдээлэлтэй танилцах боломжийг хуулиар зохицуулна.



Хялбар тендер шалгаруулалт

Интернэтэд суурилсан ХАА-ны арга

- ХАА-ны аргуудыг шинэчлэх;
- Тендер шалгаруулалт зарлах хугацааг бууруулах;
- Цахимаар үнэ дуудах;
- Бараа, үйлчилгээний цахим каталог үүсгэх.

Тендерийн үнэлгээ

- Тендер үнэлэх, гэрээ байгуулах хугацааг бууруулах;
- Үндэслэлгүй хэт бага үнэтэй тендерээс татгалзах.



Хариуцлагыг нэмэгдүүлэх

Хариуцлагын төрөл

- Хууль тогтоомж зөрчигсдөд ногдуулах хариуцлагыг тодорхой болгоно.
- Үүсгэн байгуулагчийг хуулийн этгээдийн хамт хар жагсаалтад оруулна.

Хөндлөнгийн хяналт

- Хөндлөнгийн хяналтыг тендер шалгаруулалтын явцаас гадна гэрээний хэрэгжилтэд бий болгоно.

ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ, НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ



ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ, НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- Хуулийн үйлчлэх хүрээ
- Хуулийн нэр томьёоны тодорхойлолт, зарчим
- Оролцогч, түүнд тавих шаардлага
- Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, давуу эрх тооцох

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой дараах харилцааг зохицуулахад **ХАМААРАХГҮЙ (§3.3):**

- Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авах ажиллагаа */Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журмыг Тагнуулын байгууллага боловсруулж, Засгийн газар батална./*
- Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд тусгайлан заасан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой үнэт цаас, валют худалдан авах, мөнгөн тэмдэгт хэвлүүлэх, хадгалуулах, тээвэрлэх, гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбогдуулан гадаад валют, алт худалдан авах, цэвэршүүлэх, тээвэрлэх, банкны хяналт, шалгалтын хүрээнд зөвлөх үйлчилгээ авах, үндэсний төлбөрийн системийн программ хангамж, түүний тоног төхөөрөмж, Эрдэнэсийн санг бүрдүүлэхэд хамаарах худалдан авах ажиллагаа;
- Засгийн газар, төрийн өмчит, эсхүл төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах ажиллагаа;

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой дараах харилцааг зохицуулахад **ХАМААРАХГҮЙ (§3.3):**

- Сонгуулийн ерөнхий хороо болон аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн хороо батлагдсан төсвийн хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурал, түүнчлэн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулах, сонгуулийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл, сонгогчийн бүртгэлийн техник хэрэгсэл, программ хангамж болон харилцаа холбооны үйлчилгээ худалдан авах ажиллагаа;
- Монгол Улсын хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрын хэрэгцээнд гадаад улсад худалдан авах ажиллагаа;
- Засгийн газраас Монгол Улсыг гадаад улсад сурталчлахтай холбоотойгоор гадаад улсаас бараа худалдан авах, үйлчилгээ авах, гадаад улсаас соёлын биет өв болон түүний хуулбарыг өмчлөгчтэй тохиролцон худалдан авах ажиллагаа;
- Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч оролцуулах худалдан авах ажиллагаа.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой дараах харилцааг зохицуулахад **ХАМААРУУЛНА:**

- Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах харилцаа
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан хяналт, шалгалтыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхэд мэргэшсэн этгээдийг оролцуулж, зөвлөх үйлчилгээ авах харилцаа
- Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үйл ажиллагааны тодорхой чиглэлээр шинжлэх ухааны суурь, хавсарга, технологи хөгжүүлэлтийн туршилт судалгаа болон инновацын судалгааны ажил, үйлчилгээ худалдан авах, захиалгын дагуу тухайн чиглэлийн төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаа
- Стратегийн болон батлан хамгаалах материаллаг улсын нөөц **/Улсын нөөцийн тухай хууль/**
- Олон нийтийн радио, телевиз дуу-дүрсний болон радиогийн хөтөлбөр, нэвтрүүлэг худалдан авах, дангаар болон бусадтай хамтран бүтээхэд холбогдолгүй үйлчилгээ авах, бараа, ажил худалдан авах ажиллагаа **/Олон нийтийн радио, телевизийн тухай хууль/**

ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

Эдийн засгийн ач холбогдол, үнэ бүхий худалдаж, солилцож болох зүйл болон тухайн барааг нийлүүлэхэд шаардагдах ажлыг. Ажлын үнэ нь барааны үнээс их байвал тухайн гэрээг “ажлын гэрээ” гэж тооцно.

БАРАА



ШИНЭ

Эдийн засгийн ач холбогдол, үнэ бүхий худалдах, солилцох, **түрээслэх боломжтой эд юмс, бэлэн шийдэл** бүхий биет бус хөрөнгө болон тухайн барааг дагалдан үзүүлэх ажил, үйлчилгээ (§4.1.4)

БЭЛЭН ШИЙДЭЛ

Зах зээлд бэлэн байгаа бөгөөд өөрчлөлт оруулахгүйгээр захиалагчийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжтой шийдэл (§4.1.5)

ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

“Монгол Улсын гарал үүсэлтэй бараа” гэж Монгол Улсад олборлосон, ургуулсан, бойжуулсан, үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл хийж бүтээсэн бараа буюу эд ангиудын дийлэнхийг угсарч, түүний үндсэн шинж чанар, зориулалт, ашиглалтын хэлбэрээс илт өөр болгосон шинэ бараа.

ШИНЭ

Монгол Улсад олборлосон, ургуулсан, бойжуулсан, үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, түүний үндсэн шинж чанар, зориулалт, ашиглалтын хэлбэрийг өөрчилж шинээр бүтээсэн бараа (§4.1.7)

ДОТООДЫН БАРАА



ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

- “ажил” гэж барилга байгууламжийн ажил, барилгын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, түүнчлэн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлтийг. Бараа нийлүүлэлтийн үнэ нь ажлын үнээс их байвал тухайн гэрээг “барааны гэрээ” гэж тооцно /5.1.11/;
- “барилга байгууламжийн ажил” гэж барилга байгууламжийг барих, өргөтгөл, шинэчлэлт, их засвар болон өрөмдлөг, хайгуул хийх зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг;
- “тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил” гэж энэ хуулийн 5.1.11-д зааснаас бусад тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт, тохируулга хийх ажил.
- “түлхүүр гардуулах гэрээ” гэж барилга байгууламжийн зураг төсөл, инженерийн тооцоо, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбогдсон хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн ажил, бараа, үйлчилгээг бүхэлд нь хамарсан нэг гэрээ.

ШИНЭ

Барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг барих, засварлах, өргөтгөх, буулгах, шинэчлэх, геологийн судалгаа хийх болон тэдгээрт холбогдох тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, турших, тохируулах зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг болон түүнийг дагалдан нийлүүлэх бараа (§4.1.1)

АЖИЛ



ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

- Зөвлөх үйлчилгээ болон бусад үйлчилгээ.
- “зөвлөх үйлчилгээ” гэж гүйцэтгэгчээс төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг

ЭСГҮЙЛЧЛЭГ

ШИНЭ

Энэ хуулийн 4.1.1 /ажил/-д заасан ажил гүйцэтгэхэд хамаарахгүй угсралт, суурилуулалт, туршилт, тохируулгын, эсхүл тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйл ажиллагаа (§4.1.20)



ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

50.1: ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ БАЙГАА ТӨРИЙН АЛБАН ХААГЧ

Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч

57.1: Албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ШИНЭ

52.1: ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ АЖИЛТАН, АЛБАН ТУШААЛТАН

Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан

61.1: Албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд Хөдөлмөрийн тухай

АЛБАН ХААГЧ



ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

ТЕНДЕРИЙН УРИЛГА:

Захиалагчаас тендер шалгаруулалт явуулах тухай мэдэгдсэн, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан баримт бичгийг;

Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана.

ЗАРЛАЛ / УРИЛГА



ШИНЭ

ЗАРЛАЛ:

тендер шалгаруулалт явуулах тухай цахим систем дэх мэдээлэл.

Шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана

УРИЛГА:

Захиалагчаас аж ахуй эрхлэгчийг тендер шалгаруулалтад оролцохыг урьсан баримт бичиг.

Хуульд зааснаар хүргүүлэх урилгыг тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, цахим системд бүртгүүлсэн аж ахуй эрхлэгчид нэгэн зэрэг илгээнэ.

ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;
- 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч.

ЗАХИАЛАГЧ

ШИНЭ

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;
- 50 ба түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч;
- Худалдан авах ажиллагааг энэ хуулийн дагуу зохион байгуулахаар хуульд заасан бусад этгээд.



ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

ШИНЭ

ОРОЛЦОГЧ / ТҮНШЛЭЛ

ОРОЛЦОГЧ / ТҮНШЛЭЛ

хуулийн 6.1-д зааснаар тендер ирүүлсэн аж ахуй эрхлэгч
ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮН > 20%
ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ(ИД) < 20%

СОНИРХОГЧ ЭТГЭЭД

тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар оролцох сонирхлоо илэрхийлсэн, эсхүл энэ хуульд заасан урилга хүлээн авсан аж ахуй эрхлэгч

АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ

хүн, хуулийн этгээд

ЗАХИАЛАГЧААС ХАРААТ ЭТГЭЭД

-тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын бүрэлдэхүүнийг захиалагч томилж, чөлөөлдөг; **ЭСХҮЛ**
-захиалагч нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлдог, эсхүл тодорхойлоход оролцдог.



“тендерт оролцогч” гэж **захиалагчаас хараат бус** дараах этгээдийг ойлгоно:

- дангаараа тендер ирүүлсэн этгээд;
- хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендер ирүүлсэн хэд хэдэн этгээд;

ОРОЛЦОГЧ, ТҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА



Тендер шалгаруулалтад аж ахуй эрхлэгч
дангаараа, эсхүл **түншлэлээр**
тендер ирүүлж болно.



Түншлэлийн гишүүн бүрийн гүйцэтгэх
үүрэг тендерийн үнийн **20 хувиас дээш**
байна.

20%

Оролцогч тендерийн үнийн **20 хүртэл** хувийг
нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр
туслан гүйцэтгүүлэхээр санал ирүүлж болно.

ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ

- Гэрээний үүрэг гүйцэтгэхэд бүх гишүүний хамтран болон тус бүр хүлээх үүрэг, хариуцлагыг заасан байх.
- Худалдан авах ажиллагаанд түншлэлийг төлөөлөн оролцох, гэрээний хэрэгжилтийг захиалагч болон бусад этгээдийн өмнө хариуцах нэг гишүүнийг томилсон байх.

ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

Захиалагчийн тогтоосон нөхцөл, шаардлагын дагуу боловсруулж, түүнд ирүүлсэн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх тухай сонирхогч этгээдийн санал

ТЕНДЕР



ШИНЭ

Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, эсхүл үйлчилгээ үзүүлэхээр оролцогчийн ирүүлсэн санал

ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

Хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг энэ хуульд заасан журмын дагуу шалгаруулж, бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах ажиллагаа

ШИНЭ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ

Энэ хуульд заасан журмын дагуу зарлал нийтлэх, урилга хүргүүлэх, тендер хүлээн авах, нээх, хянан үзэх, үнэлэх, захиалагч шийдвэр гаргах үйл ажиллагаа

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, **тендер шалгаруулалт** зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагаа



ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

“тендерийн баримт бичиг” гэж захиалагчаас тендерт оролцогчид зориулан гаргасан тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлагыг тодорхойлсон баримт бичгийг;

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ



ШИНЭ

захиалагчаас тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлага, аргачлалыг тодорхойлсон баримт бичиг

ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавих технологийн шаардлагыг тодорхойлсон бүрдүүлбэр

ШИНЭ

худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавигдах технологийн шаардлага, даалгаврыг тодорхойлсон бүрдүүлбэр

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

28.5: Энэ хуулийн 28.4-т заасан нэмж тооцох үнэлгээ нь зөвхөн **тендерүүдийг харьцуулах** зорилготой бөгөөд тендерийн үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

28.7.1: тендерийн үнэд арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, захиалагч энэ хуульд заасныг үндэслэн үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож **тендерийн харьцуулах үнийг** тодорхойлно;

ШИНЭ

Энэ хуульд заасны дагуу шаардлагад нийцсэн тендерийг эрэмбэлэх зорилготой тоон утга

АШИГЛАЛТЫН ХУГАЦААНЫ ӨРТӨГ

харьцуулах үнэ дээр ашиглалтын хугацаанд гарах зардлыг харгалзан тооцсон тоон утга

Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх доор дурдсан үндсэн шалгуурын аль нэгийг сонгон тендер шалгаруулалтын баримт бичигт заана:

- **харьцуулах үнэ**
- **ашиглалтын хугацааны өртөг**
- чанар ба үнийн хосолмол (эм, эмнэлгийн хэрэгсэл)

ХАРЬЦУУЛАХ ҮНЭ



ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

“ерөнхий гэрээ” гэж захиалагч нь байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээг нэг ба түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй 3 хүртэл жилийн хугацаанд үнэ болон бусад нөхцөлийг тохирч байгуулсан гэрээ

ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ АРГА



ШИНЭ

захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний **нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон** ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах

ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

ЦАХИМ ДЭЛГҮҮР

ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн хэсэг

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ

цахим программ хангамжийг ашиглан худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоо

ЦАХИМ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглан зохион байгуулах худалдан авах ажиллагаа

ШИНЭ

ЦАХИМ ДЭЛГҮҮР

ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан цахим системийн бүрэлдэхүүн

ЦАХИМ КАТАЛОГ

бараа, ажил, үйлчилгээний мэдээллийг ангилж тодорхойлсон цахим системийн бүрэлдэхүүн

ЦАХИМ СИСТЕМ

программ хангамж ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, интернэтэд суурилсан мэдээллийн систем



ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ОДОО

“өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ” гэж зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээг;

ӨӨРИЙН ХЭРЭГЦЭЭНД
ХУДАЛДАН АВАХ БАРАА,
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ



ШИНЭ

захиалагчийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ



ӨРСӨЛДӨХ
ТЭГШ
БОЛОМЖТОЙ



ИЛ ТОД



ҮР
АШИГТАЙ



ХЭМНЭЛТТЭЙ



ХАРИУЦЛАГАТАЙ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

ЗАХИАЛАГЧ:

- төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;
- 50 ба түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч;
- худалдан авах ажиллагааг энэ хуулийн дагуу зохион байгуулахаар хуульд заасан бусад этгээд.

СОНИРХОГЧ ЭТГЭЭД:

тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар оролцох сонирхлоо илэрхийлсэн, эсхүл энэ хуульд заасан урилга хүлээн авсан аж ахуй эрхлэгчийг;

ОРОЛЦОГЧ:

тендер ирүүлсэн аж ахуй эрхлэгчийг;

Аж ахуй эрхлэгч дангаараа

Түншлэлээр /гэрээний дагуу нэг тендер ирүүлсэн хэд хэдэн аж ахуй эрхлэгчийг;/

ОРОЛЦОГЧ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙНА:



1. төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эдгээртэй адилтгах нөхцөлд байгаа:
 - ✓ өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно.
/Дампуурлын тухай хуулийн 4.1/
 - ✓ Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана.
/Компанийн тухай хуулийн 26.1/
 - ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, шүүхийн шийдвэр, эрх бүхий этгээдийн шийдвэрээр үйл ажиллагааг зогсооно.

ОРОЛЦОГЧ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙНА:



2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй;



3. Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн;

- ✓ "харилцан хамаарал бүхий этгээд" гэж тухайн аж ахуй эрхлэгчтэй Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан харилцаа бүхий аж ахуй эрхлэгчийг.
/Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6/

ОРОЛЦОГЧ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙНА:



4.тухайн тендер шалгаруулалтад оролцохдоо бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцсон;

- ✓ Өрсөлдөөний тухай хуулийн 11.1.Аж ахуй эрхлэгчид өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн дараахь гэрээ, хэлцэл (картель) байгуулахыг хориглоно:

11.1.1.бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох;

11.1.2.зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл, худалдан авагчаар хуваарилах;

11.1.3.бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалт, ачилт болон тээвэрлэлт, зах зээлд нэвтрэн орох боломж, хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэлийг хязгаарлах;

11.1.4.уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, түүний нэг багц, хэсэгт харилцан хамаарал бүхий этгээдтэй хамт оролцох, эсхүл бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулах, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох.

ОРОЛЦОГЧ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙНА:



5. энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд:

- ✓ 4.1.10."захиалагчаас хараат этгээд" гэж дараах нөхцөлийн аль нэгд хамаарах этгээдийг:

4.1.10.а.тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын бүрэлдэхүүнийг захиалагч томилж, чөлөөлдөг;

4.1.10.б.захиалагч нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлдог, эсхүл тодорхойлоход оролцдог.



6. дараах этгээдийн аль нэг нь авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон:

- а.оролцогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд;
- б.оролцогчийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгч;
- в.оролцогчийн Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан.

ОРОЛЦОГЧ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙНА:



7. тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай:

- ✓ "хамаарал бүхий этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг. /Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5/
- ✓ "нэгдмэл сонирхолтой этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг. /Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.6/

8. тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй;

- ✓ 56.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын байцаагчийн саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор аж ахуй эрхлэгчийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад гурван жилийн хугацаагаар бүртгэх шийдвэрийг гаргана.

ОРОЛЦОГЧ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙНА:



9. энэ хуулийн 56.5.3, 56.5.4, 56.5.5-д заасан үндэслэлээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд.

- ✓ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6."эцсийн өмчлөгч" гэж:

3.1.6.а.харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.б.харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.в.хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг.

ДОТООДЫН БАРАА



ЗӨВХӨН ДОТООДЫН БАРАА
ҮЙЛДВЭРЛЭГЧ ХООРОНДОО
ӨРСӨЛДӨНӨ.



ЧАНАР, СТАНДАРТЫН ШААРДЛАГА
ХАНГАСАН БАРААНЫ ЖАГСААЛТ ЗГ-ЫН
ТОГТООЛООР БАТАЛНА.



ДОТООДЫН ДАВУУ ЭРХИЙН ЗӨРҮҮГ
ЗААВАЛ ТООЦНО.



ДОТООДЫН БАРААНЫ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТАД ИМПОРТЫН БАРАА
НИЙЛҮҮЛЭГЧ ОРОЛЦОХ ЭРХГҮЙ.

ГАДААДЫН ЭТГЭЭДИЙН ОРОЛЦОХ БОСГЫГ НЭМЭГДҮҮЛСЭН:

- | | |
|-------------|-----------|
| ✓ Ажил | 30 тэрбум |
| ✓ Бараа | 1 тэрбум |
| ✓ Үйлчилгээ | 300 сая |

ДОТООДЫН ДАВУУ ЭРХ ТООЦОХ

- ❖ Дотоодын бараанд 10 хувиар;
- ❖ Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бол дотоодын бараанд 15 хувиар;
- ❖ Орон нутагт үйл ажиллагаа явуулж, ажлын байр бий болгосон бол ажлын тендерийн үнийн дотоодын бараанаас бусад хэсгийн үнийн 5 хувиар;
- ❖ Ажлыг дангаар гүйцэтгэхээр, эсхүл гэрээний үүргийн 50-аас доошгүй хувийг гүйцэтгэх түншлэлд ажлын тендерийн үнийн дотоодын бараанаас бусад хэсгийн үнийн 7.5 хувиар

ТЕНДЕРИЙН ҮНИЙГ ХИЙСВЭРЛЭН БУУРУУЛНА

БАРААНД ДАВУУ ЭРХ ОЛГОХ

1. хог хаягдлыг дахин боловсруулсан;
2. хэрэглээний хог хаягдлыг дахин ашиглах, эсхүл боловсруулахаар эргүүлэн авах санал ирүүлсэн;
3. нийслэл, дүүрэг болон улсын зэрэглэлтэй хотоос бусад харьяалалтай орон нутагт үйлдвэрлэсэн түүхий эд, бараа, материалыг ашиглан үйлдвэрлэсэн;
4. Инновацийн тухай хуулийн 3.1.4-т заасан инновацийн бүтээгдэхүүн;
5. ажиллах хүчний 30 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуй эрхлэгч үйлдвэрлэсэн.

*** Ажил гүйцэтгэхэд дотоодын бараа ашиглахаар санал болговол давуу эрх олгоно.**



- дотоодын **барааны хэсгийн үнийн 10 хувиар** тендерийн үнээс хийсвэрээр бууруулж тооцно.
- оролцогч нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бол дотоодын **барааны хэсгийн үнийн 15 хувиар** тендерийн үнээс хийсвэрээр бууруулж тооцно.

АЖИЛД ДАВУУ ЭРХ ОЛГОХ



1. нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотоос бусад харьяалалтай орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зарласан тендер шалгаруулалтад оролцогч **сүүлийн хоёроос доошгүй жилийн хугацаанд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж, ажлын байр бий болгосон бол түүний тендерийн үнийн дотоодын бараанаас бусад хэсгийн үнийн 5 хувиар** хийсвэрээр бууруулж тооцно.
2. эцсийн өмчлөгч нь Монгол Улсын иргэн байх оролцогч энэ хуулийн 8.3-т зааснаас дээш төсөвт өртөгтэй ажлыг дангаар гүйцэтгэхээр, эсхүл гэрээний үүргийн 50-аас доошгүй хувийг гүйцэтгэж, энэ хуулийн 6.3.2-т заасан эрх эдлэх түншлэлийн гишүүний хувиар гүйцэтгэхээр санал ирүүлсэн бол тендерийн үнийн **дотоодын бараанаас бусад хэсгийн үнийн 7.5 хувиар** хийсвэрээр бууруулж тооцно.

Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа болон ерөнхий гэрээний аргаар худалдан авахад давуу эрх олгохгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ



ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- Тендер шалгаруулалтын баримт бичиг, техникийн тодорхойлолт боловсруулах, тодруулах
- Тендерийн баталгаа
- Тендер шалгаруулалт зарлах, хүлээн авах
- Тендер бэлтгэх, илгээх

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Захиалагчаас тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлага, аргачлалыг тодорхойлсон баримт бичгийг. (§4.1.17)



Тендер шалгаруулалтын баримт бичигт дараахыг тусгана:

- ✓ Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл,
- ✓ оролцогчид тавих шаардлага, заавар,
- ✓ хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал,
- ✓ захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд,
- ✓ техникийн тодорхойлолт,
- ✓ тендерийн жишиг маягт.


ТУСГАВАЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

- ❖ Оюуны өмчийн эрхийг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд эзэмших нөхцөл;
- ❖ Хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрөх бол энэ тухай;
- ❖ Гэрээний үнийг тохируулах бол тохируулга хийх нөхцөл, аргачлал;
- ❖ Тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан өөрчлөлт.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙГ ТОДРУУЛАХ


ТОДРУУЛГА

- тендерийн нээлтээс **ажлын таваас** доошгүй өдрийн өмнө



ХАРИУ

- Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас **ажлын хоёроос** доошгүй өдрийн өмнө



ЦАХИМ СИСТЕМД

- Нийтэлнэ



Захиалагч тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж, цахим системд нийтэлсэн бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана

Тендер нээх хугацаа тухайн нэмэлт, өөрчлөлтийг цахим системд нийтэлсэн өдрөөс хойш ажлын таваас дээш өдөр бол тендер нээх хугацааг сунгахгүй байж болно.



ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





ТЕНДЕР ҮНЭЛЭХ ҮНДСЭН ШАЛГУУР

ХАРЬЦУУЛАХ ҮНЭ

-энэ хуульд заасны дагуу шаардлагад нийцсэн тендерийг эрэмбэлэх зорилготой тоон утгыг. (§4.1.22)

АШИГЛАЛТЫН ХУГАЦААНЫ ӨРТӨГ

-харьцуулах үнэ дээр ашиглалтын хугацаанд гарах зардлыг харгалзан тооцсон тоон утгыг. (§4.1.3)

ЧАНАР БА ҮНИЙН ХОСОЛМОЛ

-Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурыг зөвхөн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад хэрэглэнэ. (§11.8)

-Чанар ба үнийн шалгуур тус бүрийн оноог тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

Дараахыг харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж тооцох бол тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно:

- ❖ бараа хүргэх, ажил, үйлчилгээ дуусгах хугацаа;
- ❖ гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээ;
- ❖ байгаль орчинд нөлөөлөх байдал;
- ❖ энэ хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавигдах технологийн шаардлага, даалгаврыг тодорхойлсон бүрдүүлбэрийг. (§4.1.18)



Техникийн тодорхойлолтод дараахыг тусгана:

- ❖ бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар түүний зориулалт
- ❖ зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага,
- ❖ зураг төсөл,
- ❖ холбогдох стандарт, норм, дүрэм, заавар.

ТУСГАВАЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

- ❖ бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлт;
- ❖ хүний эрүүл мэнд, байгаль орчин, уур амьсгалд нөлөөлөх нөлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх шалгуур үзүүлэлт;
- ❖ барилга байгууламж, дэд бүтэцтэй холбогдох техникийн тодорхойлолтод хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүн, түгээмэл загвар;
- ❖ барааг үйлдвэрлэх, нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх явцад баримтлах тусгайлсан шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгаж болно.

Төсөвт өртөг: 280.0 сая төгрөг

	Техникийн үндсэн эд ангийн нэр	Тээврийн автомашин худалдсан үндсэн шаардлага
1	Үйлдвэрлэсэн улс	БНХАУ болон бусад улс
2	Үйлдвэрлэсэн он	2015 оноос хойш
3	Орж ирсэн он	2022 он /улсын дугаар авсан байж болно/ гаалийн бичигтэй бол давуу тал болно
4	Хөдөлгүүрийн загвар	энгийн /weichai/
5	Зориулалт	Өөрөө буулгагч
6	Тэвшний багтаамж	20 м3 ба түүнтэй дүйцэхүйц
7	Дээд хурд	120 км/х
8	Цлиндрийн тоо	6/ усан хөргөлтөт, хүч нэмэгдүүлсэн турбо
9	Тэнхлэг	6*4
10	Тэвшний харьцаа	5600*2300*1500
11	Шатахууны төрөл	Дизель
12	Хурдны хайрцаг	Энгийн механик
13	Түлш зарцуулалт	35-45 л /түлш бага зарцуулдаг/
14	Үндсэн түлшний багтаамж	400 л ба түүнээс дээш
15	Дугуйн хэмжээ	12,00-20 даацын тросстой
16	Техникийн баталгаат засвар	Мотор, кроп, хүч дамжуулах ангид 1 жил, түргэн эдэлгээтэй эд ангид 6 сар
17	Дагалдах хэрэгсэл	-Иж бүрэн түлхүүр багаж хэрэгсэлтэй -Запас дугуй 1ш
18	Бусад	- Тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон бичиг баримт бүрэн, зөрчилгүй байх - Их бие, рам цуурсан, зэвэрсэн, гэмтсэн зүйлгүй байх - Гидрийн шингэн тос масло гоожилтгүй байх - Мотор трүп, шаланк, эд ангиуд хөлрөлтгүй байх - Цахилгааны асуудалгүй байх - Дугуйн хээ нь 80 хувь ба түүнээс дээш - Халуун тогоо, кабин халаагчтай байх
19	Нийт санхүүжилт	- 100,000,000 төгрөг
20	Баталгаат хугацаа	- 1 жил

Төсөвт өртөг: 100.0 сая төгрөг

1	Хог тээвэрлэх зориулалттай өөрөө буулгагч	Төрөл: Ачааны Хово машинтай дүйцэхүйц Техникийн байдал: Улсын дугаар аваагүй, шинэ, автомашины дагалдах хэрэгсэл иж бүрэн байх. Үйлдвэрлэсэн он: 2022 Хөдөлгүүрийн багтаамж: Энгийн апартуртай 3.36-аас дээш Шатахууны төрөл: Дизель Хурдны хайрцаг: Механик Хурдний хайрцаг: Зөв Хаалганы тоо: 2 Тэвшний урт: 5.40м-5.80м Тэвшний өндөр: 1.4м-1.80м Тэвшний өргөн: 2.30м Дугуй: Бүх дугуй 12.20 Кроп: Делител 10 Даац: 25тн-с багагүй Дуут дохио, чанга яригчтай Дагалдах баримтууд: Автомашины техникийн паспорт, каталог, гаалийн бичигтэй байх. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ бусад баримт бичиг бүрэн.
---	---	---

Төсөвт өртөг: 45.0 сая төгрөг

Техникийн үзүүлэлт

Үйлдвэрлэгч: БНХАУ-с

Үйлдвэрлэсэн он: 2022

Техникийн байдал: цоо шинэ

Зориулалт: өөрөө буулгагч

Даац: 5тн

Хөдөлгүүр дизель: 4 цилиндр

Хурдны хайрцаг: механик

Явах анги: 4*2

Дугуйн хэмжээ: 7.00-16


Баталгаат хугацаа: 1 жил

Дагалдах хэрэгсэл: запас дугуй 2 ш, багаж хэрэгсэл, домкрат, гаалийн бичиг, ашиглалтын заавар

Төсөвт өртөг: 175.0 сая төгрөг

Ажлын цар хүрээ: 2 ширхэг хог тээврийн автомашин худалдан авах

Явах анги	модел	EQ1056
Машины хэмжээ	мм /багагүй/	7000x2300x2700
Хог ачих багтаамж	м3 /багагүй/	8 м3-ээс дээш
Даац	кг	3000 дээш
Машины жин	кг	3800
Дээд хурд	км/цаг	90-120
Өгсөх өнцөг	град	21
Урд/хойд дугуйны мөрийн зай	мм	1506/1650
Тэнхлэгийн урт	мм	3800/4050
Тормозны зай/тормозны систем	м	42/air brake
Дугуйн томъёлол/Хөтлөгч	4x2/хойд тэнхлэг	
Хөдөлгүүрийн стандарт	Дизель хөдөлгүүр	
Хөдөлгүүрийн багтаамж		3850 дээш
Хөдөлгүүрийн чадал	квт/морины хүч	80/120
Хөдөлгүүрийн цилиндр	шр	4
Хөдөлгүүрийн үзүүлэлт	усан хөргөлт/turbo	
Хурдны хайрцаг	6-аас багагүй	
Тэнхлэгийн тоо	ш	2
Урьд тэнхлэгийн даац	тн	2.1
Хойд тэнхлэгийн даац	тн	7.0
Араа ба кроп	тоо	12/12+9 механик
Суудлын тоо	Хүн	3
Дугуй	8.25-16	6+1 (запас)
Цахилгаан	V/A	24
Шатахууны банк	литр	80-120 хүртэл





АНХААРАХ АСУУДАЛ:

- ❖ Тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.
- ❖ Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.
- ❖ Захиалагч оролцогчоос бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтод нийцэх, эсхүл гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах эсэхийг тогтоох шалгалт, туршилтыг эрх бүхий бие даасан этгээдээр хийлгэсэн нотлох баримт, эсхүл холбогдох мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.
- ❖ Шалгалт, туршилтыг хэрхэн зохион байгуулах тухай тендер шалгаруулалтын баримт бичигт зааж, оролцогчийг уг ажиллагаанд оролцох боломжоор хангана. Шалгах, турших үйл явцыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулна.

ТЕНДЕРИЙН БАТАЛГАА

- Төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол /багцгүй/
- Багцын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол

➡ 0.5%

- Банкны баталгаа;
- Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас баталгаа;
- Монгол Улсын даатгагчаас гаргасан баталгаа.

Гадаадын этгээд тендерийн баталгаа гаргуулахад:




ГАДААДЫН
ЭТГЭЭД



ГАДААД
БАНК



МОНГОЛ
УЛСЫН
БАНК



TENDER.GOV.MN

23.3.Тендерийн баталгаа шаардсан нөхцөлд түүнийг энэ хуулийн 22.7-д зааснаар ирүүлээгүй нь **тендер нээхээс татгалзах үндэслэл** болно.

ТЕНДЕРИЙН БАТАЛГАА

УЛСЫН ОРЛОГО БОЛГОХ ҮНДЭСЛЭЛ

- ! оролцогч тендерийг нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;
- ! гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй;
- ! СЯ гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

ҮНДЭСЛЭЛГҮЙ ГОМДОЛ ГАРГАСАН БОЛ УЛСЫН ОРЛОГО БОЛГОХ ХЭМЖЭЭ

20 тэрбум төгрөг төсөвт өртөгтэй бол	20 хүртэл сая төгрөг
20-100 тэрбум төгрөг төсөвт өртөгтэй бол	40 сая төгрөг
100 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бол	60 сая төгрөг

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

ШУУД ХУДАЛДАН АВЧ БОЛОХ ТӨСӨВТ ӨРТГӨӨС ДЭЭШ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛЫГ БАРИМТ БИЧГИЙН ХАМТ ЦАХИМ СИСТЕМД НИЙТЭЛНЭ.

❖ Тендер шалгаруулалтын зарлалд дараах мэдээллийг тусгана:

1. захиалагчийн нэр, хаяг;
2. тендер шалгаруулалтын нэр, дугаар, төсөвт өртөг;
3. тендер шалгаруулалтын арга;
4. тендер хүлээн авах эцсийн хугацаа;
5. тендер нээх хугацаа;
6. тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх;
7. гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх;
8. тендерийн баталгаа шаардах эсэх;
9. тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол багцын мэдээлэл.



ТЕНДЕР ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА


НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГЫН ҮЕД:

АЖЛЫН 15-ААС ДЭЭШ ӨДӨР




Хугацааны дотор тендер ирүүлнэ.

ГАДААДЫН ЭТГЭЭД ОРОЛЦОХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД АЖЛЫН
20-ООС ДЭЭШ ӨДӨР




ЦАХИМ СИСТЕМ




Захиалагч тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж, цахим системд нийтэлсэн бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.



ТООН ГАРЫН ҮСГЭЭР БАТАЛГААЖУУЛЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ ТӨЛСНӨӨР
ТЕНДЕР ИЛГЭЭНЭ.



ЦАХИМ СИСТЕМ




- ❖ Оролцогч хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээнэ.
- ❖ Тендерийн дараах баримт бичиг, мэдээллийг ил болгохыг зөвшөөрч илгээнэ:
 1. ерөнхий шаардлага хангасныг нотлох баримт бичиг;
 2. тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл;
 3. хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл;
 4. тендер шалгаруулалтын баримт бичигт ил болгохоор заасан бусад баримт бичиг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ



ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

- Тендер нээх
- Тендер хянан үзэх, үнэлэх
- Тендерийн талаар тодруулах
- Захиалагч шийдвэр гаргах, мэдэгдэх
- Тендер шалгаруулалтын мэдээллийг оролцогчид ил болгох
- Гэрээ байгуулах



ЦАХИМ СИСТЕМ

**ТЕНДЕР ХҮЛЭЭН АВАХ ЭЦСИЙН ХУГАЦАА
ДУУССАНААС ХОЙШ 1 ЦАГИЙН ДОТОР
ТЕНДЕРИЙГ НЭЭНЭ.**



Тендерийг нээж, дараах мэдээллийг цахим системээр зарлана:

1. оролцогчийн нэр;
2. тендерийн үнэ;
3. санал болгосон үнийн хөнгөлөлт;
4. хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ;
5. тендерийн баталгаа шаардсан тендер шалгаруулалтад тендерийн баталгаа ирүүлсэн эсэх.

ТЕНДЕРИЙН ТАЛААР ТОДРУУЛГА АВАХ



- ❖ Захиалагч тендерийн тодорхойгүй, эсхүл зөрчилдөөнтэй асуудлаар тодруулга авах нь бусад оролцогчийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөхгүй бол **оролцогчоос** бичгээр тодруулга авах хүсэлт хүргүүлэх ба хүсэлтэд хариу ирүүлэх хугацааг заана.
- ❖ Захиалагч дээр дурдсан тодруулгыг **холбогдох бусад этгээдээс** цахим систем, цахим шуудангаар, эсхүл албан бичгээр авч болно.

Тендерийн талаар тодруулахад анхаарах асуудал:

1. Тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэх зорилгоор нэмэлт баримт бичиг, загвар, дээж ирүүлэхийг шаардахгүй.
2. Тендерийн арифметик алдааг залруулснаас бусад тохиолдолд тендерийн үнэ, үнийн хөнгөлөлтийн талаар тодруулга авах хүсэлт гаргахгүй.
3. Тендерийн талаар тодруулга авах захиалагчийн хүсэлтэд заасан хугацааны дотор оролцогч хариу ирүүлээгүй нь хянан үзэх, үнэлэх ажиллагааг хойшлуулах үндэслэл болохгүй.

ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХЭД:

1. Ерөнхий шаардлага хангасан эсэхийг оролцогчийн мэдэгдэл, цахим системд ирүүлсэн мэдээлэлд үндэслэх;
2. хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлагыг хангасан байх;
3. санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх;
4. захиалагчаас тогтоосон, эсхүл холбогдох гэрээний нөхцөлөөр тодорхойлсон талуудын эрх, үүргийг хүлээн зөвшөөрсөн байх;
5. тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх.



ЗАХИАЛАГЧ



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ,
ИТА-НЫ БҮРТГЭЛ



ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
БҮРТГЭЛ



ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛ,
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



ШШГЕГ ЛАВЛАГАА



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ



ШИЛЭН ДАНС



ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ



ТӨРИЙН САН

ТУРШЛАГА,
ЧАДАВХЫН
МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН БҮРТГЭЛ





Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

Шаардлагад нийцсэнээс бусад тендерээс татгалзана:

1. тендерийн үнэ төсөвт өртгөөс, эсхүл нэгж дээд үнээс хэтэрсэн;
2. дотоодын барааны багцад импортын бараа санал болгосон;
3. тендер шалгаруулалтын баримт бичигт шаардсан оролцогчийн хүлээх үүрэг, хариуцлагыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл мэдэгдлийг үнэн зөвөөр гаргаагүй;
4. төсөвт өртгийн 80 хувиас доош үнэтэй тендерт тайлбар ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн.



Шаардлагад нийцсэн тендерийг үнэлгээний үндсэн шалгуурын дагуу үнэлнэ.

Тендерийн нээлтэд зарлагдсан тендерийн үнэ, үнийн хөнгөлөлтөд үндэслэн харьцуулах үнийг дараах байдлаар тооцно:

1. үнийн хөнгөлөлтийг оролцогчоос ирүүлсэн аргачлалын дагуу тооцох, аргачлал ирүүлээгүй бол тендерийн үнээс тооцох;
2. тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар гадаад валютаар ирүүлсэн тендерийн үнийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Монголбанкны албан ханшаар тооцож хөрвүүлэх;
3. давуу эрх олгож харьцуулах үнийг хийсвэрээр бууруулах;
4. тендер шалгаруулалтын баримт бичигт үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт хэрэглэхээр тусгасан бол мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх.



АРИФМЕТИК АЛДАА ЗАЛРУУЛАХАД:

1. Үнэлж байгаа тендерийн үнэд арифметик алдаа байвал захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар залруулж, энэ тухай оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрөх эсэх талаар бичгээр хариу ирүүлэхийг шаардана.
2. Оролцогч арифметик алдааг хүлээн зөвшөөрсөн бол залруулсан үнийг энэ хуулийн 27.2-т зааснаар үнэлнэ.



ТЕНДЕРИЙГ ЭРЭМБЭЛЭХЭД:

1. Тендерийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.
2. Хоёр ба түүнээс дээш тооны тендерийн харьцуулах үнэ, эсхүл оноо тэнцүү бол хугацааны хувьд цахим системд түрүүлж ирсэн тендерийг эхэнд эрэмбэлнэ.



- ❖ Захиалагч тендер нээсэн даруй тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлж, холбогдох шийдвэрийг тендер нээснээс хойш **ажлын 15 өдрийн дотор** гаргана.
- ❖ Гэрээ шууд байгуулах аргын хувьд холбогдох шийдвэрийг тендер нээснээс хойш **ажлын 5 өдрийн дотор** гаргана.
- ❖ СЯ-д гомдол гарсан, эсхүл давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас шалтгаалсан бол захиалагч **ажлын 15 хүртэл өдрөөр нэг удаа сунгаж болно.**

Захиалагч тендер тус бүрд дараах шийдвэрээс аль тохирохыг гаргаж, оролцогчид нэгэн зэрэг мэдэгдэнэ:

1. хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчид **гэрээ байгуулах эрх олгох**;
2. шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн боловч хамгийн сайн тендер ирүүлээгүй бусад оролцогчийн тендер **шалгараагүй тухай**;
3. шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн **тендерээс татгалзах.**



АНХААРАХ АСУУДАЛ:

- ❖ Захиалагч шийдвэрийг цахим системд нийтэлснээр мэдэгдсэнд тооцно.
- ❖ Захиалагч хамгийн сайн тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсэн бол уг үнийг гэрээний үнээр тогтоож, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт заана.
- ❖ Захиалагч хуульд заасан хугацаанд шийдвэр гаргаагүй бол тухайн төсвийн жилд тухайн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулахыг хориглоно.
- ❖ Тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй бол захиалагч тендер ирээгүй шалтгааныг судалж, худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулах эсэхийг шийдвэрлэнэ.
- ❖ Захиалагч бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, дахин тендер шалгаруулалт зарлах эсэх мэдээллийг шийдвэрт заана.
- ❖ Захиалагч бүх тендерээс татгалзсантай холбоотойгоор дахин тендер шалгаруулалт зарлах тохиолдолд Сангийн яаманд гомдол гаргах хугацаа дуусаагүй байхад дараагийн тендер нээхийг хориглоно.
- ❖ Захиалагч шийдвэр гаргах, эсхүл гэрээ байгуулах хүртэл хугацаанд оролцогчийг тендерийн хүчинтэй байх хугацааг сунгуулах хүсэлтийг гаргаж болох ба оролцогч хугацааг сунгах бол захиалагчид бичгээр мэдэгдэнэ.

ОРОЛЦОГЧДОД ИЛ БОЛГОХ



**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**



**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ
ШИЙДВЭР**



ЗАХИАЛАГЧИЙН ШИЙДВЭР



**ШАЛГАРСАН КОМПАНИЙН
ТЕНДЕРИЙН НУУЦЛААГҮЙ ХЭСЭГ,
ТЕНДЕРТ ИРҮҮЛСЭН ТОДРУУЛГА**



**ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ,
ТҮҮНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**



**ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ
ГҮЙЦЭТГЭЛ**



**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ҮНЭ,
АРИФМЕТИК АЛДААГ
ЗАЛРУУЛСАН БОЛ УГ МЭДЭЭЛЭЛ**



**ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ**



Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш **ажлын 6-аас доошгүй өдрийн дараа**, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар, эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ.

Захиалагч доор дурдсанаас бусад тохиолдолд шалгарсан оролцогчтой гэрээ байгуулна:

1. энэ хуулийн 14.6.2-т заасан нөхцөл үүссэн;
2. Сангийн яам, эсхүл шүүхийн шийдвэрээр тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн, гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгосон, эсхүл тендер шалгаруулалтыг хүчингүйд тооцсон.

Захиалагч гэрээ байгуулах хугацааг дараах тохиолдолд баримтлахгүй байж болно:

1. тендер шалгаруулалтад нэг оролцогч тендер ирүүлж шалгарсан;
2. гэрээ шууд байгуулах аргад заасан үндэслэлээр гэрээ байгуулах;
3. ерөнхий гэрээ байгуулах, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах.

- ❖ **Захиалагч шалгарсан оролцогчийн баталгаажуулан ирүүлсэн гэрээг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор, энэ хуулийн 49.4.13-т заасан мэдэгдлийн дагуу гэрээ байгуулах тохиолдолд ажлын 10 өдрийн дотор тус тус гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцно. (§30.4)**
- ❖ **Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тухайн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хэрэгцээ шаардлага байхгүй болсон, эсхүл бараа, ажил, үйлчилгээ худалдан авах санхүүжилтийн эх үүсвэргүй болсон тохиолдолд энэ хуулийн 30.4 дэх хэсэг хамаарахгүй. (§30.5)**
- ❖ **Санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тодотгол хийснээс бусад тохиолдолд захиалагч энэ хуулийн 30.5-д заасан үндэслэлээр худалдан аваагүй бараа, ажил, үйлчилгээг тухайн төсвийн жилд дахин худалдан авахыг хориглоно.**
- ❖ **Энэ хуульд зааснаар нээлттэй тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулсан бол холбогдох зээл, тусламжийн гэрээ байгуулагдах хүртэл худалдан авах гэрээ байгуулахыг хориглоно.**

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА

ЦАХИМ СИСТЕМД СУУРИЛСАН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА

Нээлттэй тендер шалгаруулалтын арга:

- Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.
- Нээлттэй тендер шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулж болно.

Харьцуулалтын арга:

- Цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулна.
- Харьцуулалтын аргаар худалдан авах бараа цахим каталогт бүртгэгдсэн байна.

Гэрээ шууд байгуулах арга:

- Захиалагчаас үл хамаарах яаралтай нөхцөлийн үед тухайн салбарын аж ахуй эрхлэгч нартай хэлэлцээ хийж, тендер хүлээн авна.

Нэг үүсвэрээс худалдан авах арга:

- Оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар болон зөвхөн үйлдвэрлэгчээс нь худалдан авах бол нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар зохион байгуулна.

Ерөнхий гэрээний арга:

- Бараа, үйлчилгээнд 3 хүртэл жилийн хугацаатай ерөнхий гэрээ байгуулна.
- Нийлүүлэгчийн бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт нэгж үнээр байршуулж, захиалагч цахим дэлгүүрээс худалдан авна.

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА

Нээлттэй тендер шалгаруулалтыг **хоёр үе шаттай** зохион байгуулах

(цар хүрээ, төсөвт өртөг өндөр, хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг цогцоор нь гүйцэтгэх шаардлагатай бөгөөд техникийн тэгш бус санал ирэх магадлалтай, эсхүл шаардлага хангах, ижил хэмжээнд хүлээн зөвшөөрөхүйц хоёр ба түүнээс дээш техникийн шийдэл байх боломжтой гэж үзсэн бол)

Нэгдүгээр үе шат:

Захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон **техникийн тодорхойлолт бүхий тендер шалгаруулалтын баримт бичгийг** боловсруулж, зарлал нийтэлнэ.

техникийн санал ирүүлэх сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангах бараа, ажил, үйлчилгээний **шийдлийг санал** болгоно.

Хоёрдугаар үе шат:

техникийн шийдлийг судалж, тендер шалгаруулалтын баримт бичгийг эцэслэн боловсруулж, **урилгыг нэгдүгээр үе шатанд оролцсон этгээдэд** хүргүүлнэ.

Нээлттэй тендер шалгаруулалтад тендер хүлээн авах хугацааг баримтлах бөгөөд **нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер** ирүүлнэ.

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГА



Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээ /Бараа цахим каталогт бүртгэгдсэн байна./



Тендер шалгаруулалтын **зарлал** нийтэлж, бүртгэлтэй аж ахуй эрхлэгчид **урилга** хүргүүлнэ. Тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим системд нийтэлнэ.



Урилга хүргүүлсэн өдрөөс хойш **ажлын 5-аас доошгүй өдрийн** дараа үнийн саналыг дуудна.

/Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдэд цахим системээс ялгах дугаар олгоно./



Заасан хугацаанд сонирхогч этгээд **тендерийг цахим системд ирүүлнэ.**



Үнийн санал дуудах ажиллагааг **2-оос доошгүй цагийн** хугацаагаар зохион байгуулна.

Уг хугацааны дотор саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно.



Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад өсөх дарааллаар **эхэнд эрэмбэлэгдсэн** үнийн санал бүхий оролцогчийг тодорхойлно.



Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн **тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно.**



Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн **тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.**



“НҮБ-ын стандарт бараа, үйлчилгээний код”
5 шатлалын ангилалтай 8-аас 10 орон бүхий
кодчиллын стандарт

Жишээ: Модон харандаа /44121706/

Сегмент: 44 Оффисын тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, хангамж

Төрөл: 12 Оффисын хангамж

Анги: 17 Бичгийн хэрэгсэл

Бүтээгдэхүүн: 06 Модон харандаа




“Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”
21 хэсэг, 99 бүлэг, дэд бүлэг, зүйл, мөр гэсэн бүтэцтэй

Жишээ: Ногоон цай /0902.10/

Хэсэг: 09 Кофе, цай, мате ба халуун ногоо

Бүлэг: 09.02 Цай, амт орсон эсэхээс үл хамаарна

Дэд бүлэг: 0902.10 Ногоон цай



www.tender.gov.mn
ЦАХИМ КАТАЛОГ



Захиалагч



Аж ахуй
эрхлэгч

Бараа, ажил, үйлчилгээг
цахим каталогт бүртгэнэ



ТХААГ

Бараа, ажил,
үйлчилгээний бүртгэлийг
баталгаажуулна.

ГЭРЭЭ ШУУД БАЙГУУЛАХ АРГА



Зөвхөн хуульд заасан
үндэслэлээр гэрээ шууд
байгуулах аргыг хэрэглэнэ.



Зарлалыг бараа, ажил,
үйлчилгээний ерөнхий
мэдээллийн хамт нийтэлж,
бүртгэлтэй аж ахуй эрхлэгчид
хэлэлцээ хийх урилга
хүргүүлнэ.



Хэлэлцээнд оролцох
сонирхлоо илэрхийлэх
хугацааг зарлал, урилга
хүргүүлснээс хойш **ажлын**
5 өдөр, хэлэлцээг
сонирхлоо илэрхийлэх
хугацаанаас хойш **ажлын**
3-аас доошгүй өдөр
байхаар заана.



Захиалагч хэлэлцээг зарлалд
заасан хугацаанд **сонирхогч**
этгээдтэй нэгэн зэрэг хийнэ.

Хэлэлцээгээр техникийн
тодорхойлолт, санхүүжилтийн
болон гэрээний нөхцөлийн
талаар солилцоно.



Захиалагч хэлэлцээний
үндсэн дээр баталсан тендер
шалгаруулалтын баримт
бичгийг цахим системд
нийтэлж, тендер хүлээн авах
эцсийн хугацааг **ажлын 7-оос**
доошгүй өдөр байхаар
заана.




Хэлэлцээнд оролцсон
этгээд **тендер ирүүлэх**
эрхтэй байна.
Тендерийг хуульд заасны
дагуу хянан үзэж, үнэлнэ.

НЭГ ЭХ ҮҮСВЭРЭЭС ХУДАЛДАН АВАХ АРГА

Захиалагч дараах нөхцөлд нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж болно:

1. оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэгч оюуны өмчийн эрх эзэмшигч, эсхүл түүнээс лицензийн гэрээний дагуу ашиглах эрх авсан албан ёсны **нэг этгээд гүйцэтгэх боломжтой бол;**
2. олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг **гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол;**
3. нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн **20 хувиас хэтрэхгүй** нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;
4. нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан ажлын нэмэлт ажлын өртөг анхны гэрээний үнийн **15 хувиас хэтрэхгүй нөхцөлд** тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол;
5. төрийн болон орон нутгийн өмчийн музей болон галерейн сан хөмрөгийг баяжуулах зорилгоор түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг **нэг өмчлөгчөөс худалдан авах шаардлага үүссэн бол;**
6. төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах үед үйлдвэрлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах нөхцөлд тухайн бараа, тоног төхөөрөмжийн **үйлдвэрлэгчээс худалдан авах бол.**

ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ АРГА



ЦАХИМ ДЭЛГҮҮР



✓ ӨДӨР ТУТАМ, ЖИЛ БҮР
АВДАГ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭГ
НЭГЖ ҮНЭЭР АВНА.



✓ ДОТООДЫН БАРААГ
ЦАХИМ ДЭЛГҮҮРЭЭС
ХУДАЛДАЖ АВНА.



✓ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
ХАНГАСАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН
ТООГ ХЯЗГААРЛАХГҮЙ.




✓ 3 ХҮРТЭЛ ЖИЛЭЭР
ГЭРЭЭ БАЙГУУЛНА.



✓ ШУУРХАЙ ХУДАЛДАН АВАЛТ
ХИЙХ БОЛОМЖТОЙ,
СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС
СЭРГИЙЛНЭ.



НИЙЛҮҮЛЭГЧ



ЗАХИАЛАГЧ

TENDER.GOV.MN /ESHOP/



100 ХУВЬ
ЦАХИМ
ХЭЛБЭРЭЭР



СТАТИСТИК
ТООН
МЭДЭЭЛЭЛ



ЦАГ
ХУГАЦАА
ХЭМНЭСЭН



ҮР АШИГТАЙ,
ХЭМНЭЛТТЭЙ

ТАВДУГААР БҮЛЭГ.

ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ



Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид "худалдан авах гэрээ" гэх/-ний гол нөхцөл нь **тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер** байна.

Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

1. гэрээний үнэ;
2. гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл;
3. төлбөрийн нөхцөл, хугацаа;
4. урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн баталгааны дүн;
5. захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэр;
6. бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх хуваарь;
7. давуу эрх тооцсон бараа, материал, ажиллах хүчний мэдээлэл;
8. гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал;
9. түншлэл, туслан гүйцэтгэгчийн мэдээлэл;
10. гэрээ цуцлах болон гэрээнээс татгалзах үндэслэл, журам;
11. тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл.

Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай **шийдвэрт заасан үнээр** тогтооно.

ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ



Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах **нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй** байршуулна.



Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно:

1. хуулийн 40.1-д зааснаас **бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;**
2. гүйцэтгэгч гэрээний үүргийг **гуравдагч этгээдэд шилжүүлэх.**



Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

1. захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр **гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах;**
2. гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар бараа, ажил, үйлчилгээний **тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдсөнтэй** холбоотойгоор гэрээний үнийг тохируулах.

ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ



Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулснаар гүйцэтгэгч энэ хуулийн 7.1.1, 7.1.6, 7.1.8, 7.1.9-д заасан нөхцөл үүссэн бол гэрээний үүргийг зөрчсөнд тооцно.

- 7.1.6.дараах этгээдийн аль нэг нь авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон:
 - 7.1.6.а.оролцогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд;
 - 7.1.6.б.оролцогчийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгч;
 - 7.1.6.в.оролцогчийн Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан.
- 7.1.8.тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй;
- 7.1.9.энэ хуулийн 56.5.3, 56.5.4, 56.5.5-д заасан үндэслэлээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд.

Байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний нэгж үнэ болон бусад нөхцөлийг гурав хүртэл жилийн хугацаанд тогтоох нөхцөлтэй байгуулсан гэрээний хугацааг сунгахыг хориглоно.

ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ



Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна:

1. энэ хуулийг зөрчиж **гэрээ шууд байгуулсан**;
2. энэ хуулийг зөрчиж **нэг эх үүсвэрээс худалдан авсан**;
3. хуульд зааснаар **зарлал нийтлээгүй, эсхүл урилга хүргүүлээгүй**;
4. шалгарсан оролцогчийн тендерийн нууцлаагүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулгатай **танилцах эрхийг хязгаарласан**;
5. тендер хүлээн авах эцсийн хугацааг, эсхүл энэ хуулийн 30.1-д заасан гэрээ байгуулах хугацааг баримтлаагүй;
6. захиалагчийн энэ хуульд заасан бусад зөрчил нь тендер шалгаруулалтын эцсийн дүнд илт нөлөөлсөн.

Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлаагүй бол уг нэмэлт, өөрчлөлт илт хууль бус байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА

Төсөвт өртөг 100
сая төгрөгөөс
дээш бол

➔ 3%

- Банкны баталгаа;
- Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны баталгаа;
- Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны баталгаа;
- Монгол Улсын даатгагчаас гаргасан баталгаа.

Гадаадын этгээд гүйцэтгэлийн баталгаа гаргуулахад:


ГАДААДЫН
ЭТГЭЭД





ГАДААД
БАНК




МОНГОЛ
УЛСЫН
БАНК




TENDER.GOV.MN

Төсвийн жил дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааны хугацаа дуусахаас өмнө захиалагчид гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлнэ. Гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол түүнийг гэрээний үүргээ зөрчсөнд тооцож, гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн орлого болгоно.

- Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгааг баталгаажуулах
- Хуульд заасан зүгшрүүлэх, тохируулах хугацаанд



5-10%

- Банкны баталгаа;
- Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны баталгаа;
- Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны баталгаа;
- Монгол Улсын даатгагчаас гаргасан баталгаа.


Барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.

УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР, ТҮҮНИЙ БАТАЛГАА



Тендер
шалгаруулалтын
баримт бичигт
заасан бол

**Ажлын бэлтгэл
хангахад
зориулан**



Оролцогч урьдчилгаа
төлбөрөөс багагүй дүнтэй
баталгаа гаргасан бол
урьдчилгаа төлбөр олгоно.

Урьдчилгаа төлбөрийн баталгаа:

- Банкны баталгаа;
- Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны баталгаа;
- Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны баталгаа;
- Монгол Улсын даатгагчаас гаргасан баталгаа.

- Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно.
- Урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд гүйцэтгэлийн баталгааны дүнг оруулан тооцож болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



**САНХҮҮЖИЛТИЙН ЭХ
ҮҮСВЭР БАТЛАГДАНА.**



ЗАХИАЛАГЧ

Батлагдсан
төсөвт туссан
төсөл, арга
хэмжээ бүрээр
худалдан авах
ажиллагааг үр
ашигтай
төлөвлөж,
батална.



**ДЭЭД ШАТНЫ
ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ**




**ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧ**

Захиалагчийн
худалдан авах
ажиллагааны
төлөвлөгөөг
нэгтгэн хянаж,
баталгаажуулан
цахим системд
нийтэлнэ.

хойш ажлын 10 өдрийн дотор

хойш нэг сарын дотор



ХАА ЗОХИОН БАЙГУУЛАХ



ТХААГ

- Засгийн газраас баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээ.



АЙМАГ, НИЙСЛЭЛИ ЙН ЗАСАГ ДАРГА

- Засгийн газраас баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээ.



ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

- Засгийн газраас баталсан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа ажил, үйлчилгээ.



ЗАХИАЛАГЧ

ХАМААРАХГҮЙ БУСАД БҮХ
САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС
ХУДАЛДАН АВАХ БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ

- Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна.
- Засаг даргын өөрийн хэрэгцээнд худалдан авахаас бусад тохиолдолд тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж зохион байгуулна.

ЗАХИАЛАГЧ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫГ ТӨВЛӨРҮҮЛЭН, НЭГТГЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ



ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрснөөр харьяа байгууллагын төсвийн хүрээнд нэг төрлийн бараа, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг төвлөрүүлэн зохион байгуулж болно.



МЭРГЭЖЛИЙН
БАЙГУУЛЛАГА

2 ба түүнээс дээш төсвийн шууд захирагч дараах нөхцөлийн аль нэгд үндэслэн тендер шалгаруулалтыг хамтран зохион байгуулах хүсэлтийг мэргэжлийн байгууллагад хүргүүлж болно:

1. тодорхой зорилгыг хамтран хэрэгжүүлэх бол;
2. ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх боломжтой бол.

Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.

ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

1. худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;
2. үнэлгээний хороо байгуулах;
3. үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих;
4. энэ хуульд заасан хугацаанд шийдвэр гаргах;
5. тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх;
6. худалдан авах гэрээ байгуулах;
7. худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх;
8. энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах;
9. энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;
10. энэ хуулийн 56.5-д заасан нөхцөл илэрсэн оролцогчийн талаарх мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт худалдан авах ажиллагааны улсын байцаагчид хянуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
11. гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх;
12. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах;
13. хуульд заасан бусад.

- **Захиалагч гэрээ шууд байгуулсан, эсхүл нэг эх үүсвэрээс худалдан авсан бол гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.**
- **Захиалагч энэ хуулийн 7.1.4-т заасан нөхцөл үүссэн, эсхүл энэ хуулийн 52 дугаар зүйлд заасан ажилтан, албан тушаалтанд нөлөөлсөн гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд захиалагч холбогдох хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ХУВИЙН ХЭРЭГ



1. санхүүжилтийн эх үүсвэр баталсан шийдвэр;
2. нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгох болсон үндэслэл;
3. захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
4. захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг;
5. оролцогчдын ирүүлсэн тендер;
6. үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж;
7. тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл;
8. захиалагчийн шийдвэр;
9. худалдан авах гэрээ;
10. энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг;
11. бусад баримт бичиг.

Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална.

ХАА-НЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА



МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэх ба аймаг, нийслэл, дүүрэгт худалдан авах ажиллагааны нэгжтэй байна.

Аймаг, нийслэл, дүүрэг дэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг тухайн шатны Засаг дарга худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай, дүүрэг дэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг дүүргийн Засаг дарга мөн нийслэлийн Засаг даргатай тус тус зөвшилцөн томилж, чөлөөлнө.

Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгжийн дарга нь:

- ял шийтгүүлж байгаагүй,
- төрийн албанд 6-аас дээш жил, үүнээс худалдан авах ажиллагааны чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагатай,
- сүүлийн 3 жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхлээгүй байна.

1. цахим системийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;
2. захиалагчийн энэ хуулийн 48.2.6, 48.2.7, 48.2.11-д зааснаас бусад эрх эдэлж, үүрэг хүлээх;
3. ерөнхий гэрээ байгуулахтай холбоотойгоор энэ хуулийн 48.2.11-д зааснаас бусад захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх;
4. худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
5. цахим системийн ашиглалт, худалдан авах ажиллагааны талаар сургалт зохион байгуулах;
6. цахим систем, түүний бүрэлдэхүүн хэсгийн хэвийн үйл ажиллагааг хариуцан, цахим системийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг тогтмол нэмэгдүүлэх;
7. энэ хуулийн 22.10-т заасан хураамжийн 30 хүртэл хувийг цахим системийн найдвартай ажиллагаа, шинэчлэл сайжруулалт, аюулгүй байдлыг хангахад зарцуулах;
8. энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан бүртгэлийн тогтолцоо үүсгэх, хөтлөх, боловсронгуй болгох;
9. цахим системийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, холбогдох мэдээ, тоо баримтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
10. бараа, ажил, үйлчилгээний жишиг техникийн тодорхойлолт боловсруулах, ерөнхий гэрээ байгуулах бараа, үйлчилгээг тодорхойлох зорилгоор зах зээлийн судалгаа хийх;
11. ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийн дээд хязгаарыг тогтоох, ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулах;
12. энэ хуульд заасан баталгааг цахим системээр гаргах эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
13. шалгарсан оролцогчтой худалдан авах гэрээ байгуулах тухай мэдэгдлийг гэрээ байгуулах эрх бүхий этгээдэд хүргүүлэх;
14. захиалагч, эрх бүхий этгээдээс ирүүлсэн мэдэгдлийн дагуу худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг хүчингүй болгох;
15. энэ хуульд заасан бусад.

1. цахим системийн ашиглалт, худалдан авах ажиллагааны талаар сургалт зохион байгуулах;
2. энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан бүртгэлийн тогтолцоо үүсгэх, хөтлөх, боловсронгуй болгох;
3. бараа, ажил, үйлчилгээний жишиг техникийн тодорхойлолт боловсруулах, ерөнхий гэрээ байгуулах бараа, үйлчилгээг тодорхойлох зорилгоор зах зээлийн судалгаа хийх;



мэргэжлийн холбоо,
иргэний нийгмийн
байгууллагаар гэрээний
үндсэн дээр гүйцэтгүүлж
болно.

Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн саналаа худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
2. захиалагчийн энэ хуулийн 48.2.6, 48.2.7, 48.2.11-д зааснаас бусад эрх эдэлж, үүрэг хүлээх;
3. худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 49.4.10-т заасан судалгаа хийх;
4. цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахад дэмжлэг үзүүлж, сургалт зохион байгуулах;
5. энэ хуулийн 49.4.13-т заасан чиг үүрэг.



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

Захиалагч шууд худалдан авалтаас бусад тохиолдолд үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:

- 100 сая төгрөг хүртэл төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын үнэлгээний хороог гурваас доошгүй;
- ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны, эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй.

Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах;
2. тендерийг нээх, хянан үзэх, үнэлэх;
3. захиалагчид энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргах зөвлөмж хүргүүлэх.

- Үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна.
- Үнэлгээний хорооны гишүүний гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус гишүүн байна.
- Хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, ТББ-ын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.

- Үнэлгээний хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон, энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан үүргээ зөрчсөн бол захиалагч түүнийг үнэлгээний хорооны гишүүний үүргээс чөлөөлж, шинэ гишүүн нөхөн томилно.
- Захиалагч үнэлгээний хорооны хараат бус, бие даасан байдлыг хангах зорилгоор энэ хуулийн 50.2.1-д заасан чиг үүргийг гүйцэтгэснээр үнэлгээний хорооны чиг үүрэг дуусгавар болохоор байгуулж болно.
- Энэ тохиолдолд энэ хуулийн тендерийг нээх, хянан үзэх, үнэлэх, захиалагчид шийдвэр гаргах зөвлөмж хүргүүлэх чиг үүрэгтэй үнэлгээний хороог шинээр байгуулна.
- Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлыг товлон, тогтоосон хугацаанд шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Үнэлгээний хороо тендер шалгаруулалттай холбоотой асуудлаар захиалагчаас бусад этгээдтэй харилцахыг хориглоно.
- Үнэлгээний хороо шаардлагатай асуудлаар захиалагчаар дамжуулан харилцана.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРАЛ

- Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал байна.
- Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ.
- Үнэлгээний хороо нийт гишүүний дөрөвний гурваас багагүй тооны гишүүний ирцтэй хуралдсанаар хурлыг хүчинтэйд тооцно.
- Тендер хянан үзэх, үнэлэхэд энэ хуульд заасан үндэслэлээр холбогдох этгээдээс тодруулга авах шаардлагатай гэж үзвэл үнэлгээний хорооны хурлыг хойшлуулж болно.
- Хууль тогтоомжид заасан үндэслэлээр эрх бүхий байгууллагаас тогтоосон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон болон түүнтэй адилтгах бусад нөхцөл байдлаас шалтгаалан хуралд үнэлгээний хорооны бүх, эсхүл зарим гишүүд биечлэн оролцох боломжгүй бол тухайн гишүүдийг хуралд цахим хэлбэрээр оролцуулж болно.
- Үнэлгээний хорооны хуралд цахимаар оролцсон гишүүнийг ирцэд оруулан тооцож, хурлын тэмдэглэлд цахим системээр баталгаажуулна.
- Үнэлгээний хорооны хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- Үнэлгээний хорооны гишүүд хуралд биечлэн оролцсон эсэхээс үл хамааран зөвлөмжтэй танилцаж, түүнийг дэмжих эсэх саналаа тусган цахим системээр баталгаажуулах үүрэгтэй.

АЖИЛТАН, АЛБАН ТУШААЛТНЫ ҮҮРЭГ



Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх үүргийг хүлээнэ.

- Худалдан авах ажиллагаанд оролцох ажилтан, албан тушаалтан энэ хуульд зааснаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад цаг тухайд нь оролцох үүрэгтэй.
- Худалдан авах ажиллагаанд оролцох ажилтан, албан тушаалтан дараах үүргийн аль нэгийг хэрэгжүүлээгүй нь түүнийг тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой чиг үүргээс чөлөөлж, эрх бүхий этгээд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно:
 1. ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд захиалагчид мэдэгдээгүй, эсхүл худал мэдүүлсэн;
 2. ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар гаргаагүй, эсхүл худал мэдүүлсэн;
 3. худалдан авах ажиллагаанд холбогдох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн.

БҮРТГЭЛИЙН ТОГТОЛЦОО


**АЖ
АХУЙ ЭРХЛЭГЧ**


ЗАХИАЛАГЧ


**ХАА
МЭРГЭШСЭН
АЖИЛТАН**


**БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
КАТАЛОГ**



**ТУРШЛАГА,
ЧАДАВХЫН
МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН БҮРТГЭЛ**



TENDER.GOV.MN

- Захиалагч цахим системд бүртгүүлснээр худалдан авах ажиллагаа зохион байгуулна.
- Аж ахуй эрхлэгч цахим системд бүртгүүлж, тус системд холбогдсон төрийн эрх бүхий байгууллагын мэдээллийн сангаас оролцож байгаа тендер шалгаруулалттай холбоотойгоор түүний мэдээллийг цахим системээр харилцан дамжуулахыг хүлээн зөвшөөрсөн байна.
- Цахим системд бүртгүүлсэн аж ахуй эрхлэгч энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага, энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадавх, туршлагын шаардлагыг хангасан талаарх мэдээлэл, баримт бичгийг оруулан өөрийн хувийн бүртгэлийг үүсгэнэ.
- Аж ахуй эрхлэгчийн туршлага, гэрээний үүргийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг холбогдох төрийн эрх бүхий байгууллага болон захиалагч баталгаажуулснаар худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цахим системд бүртгэнэ.

САНГИЙН ЯАМНЫ БҮРЭН ЭРХ

1. худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;
2. худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагчийн хүсэлтээр мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;
3. худалдан авах ажиллагаатай холбоотой журам, аргачлал, заавар, тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг, гэрээний загварыг батлах;
4. энэ хуульд зааснаар тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргах, тендерийн баталгааг улсын орлого болгох журмыг батлах;
5. тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон журам батлах;
6. худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх;
7. худалдан авах ажиллагааны тайланг улсын хэмжээнд нэгтгэж, мэдээлэл гаргах;
8. худалдан авах ажиллагаанд оролцох ажилтан, албан тушаалтны чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах;
9. худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хяналт тавих чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;
10. худалдан авах ажиллагааны асуудлаар олон улсын байгууллага, гадаад улсын бусад байгууллагатай хамтран ажиллах;
11. энэ хуулийн 56.6.1-д заасан жагсаалт хөтлөх, хяналт тавих, мэдээлэх;
12. хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр энэ хуулийн хэрэгжилттэй холбогдуулж тодорхой асуудалд зөвлөмж өгөх;
13. хуульд заасан бусад.

ХАА-НЫ УЛСЫН БАЙЦААГЧ



Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагч байна.

Улсын байцаагч оролцогчтой холбоотой дараах нөхцөлийн талаар дүгнэлт гаргана:

1. худалдан авах ажиллагаанд оролцоход оролцогчийн ерөнхий болон чадавхын шаардлага, туршлагыг хангах талаар хуурамч баримт бичиг, эсхүл бусад этгээдийн баримт бичгийг өөрчилж тендер ирүүлсэн;
2. энэ хуулийн 7.1.3, 7.1.6, 7.1.7, 7.1.9-д заасан нөхцөлийн талаар худал мэдүүлсэн тендер ирүүлсэн;
3. улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр худалдан авах гэрээний үүргээ гүйцэтгээгүйн улмаас гэрээ цуцлагдсан, гэрээнээс татгалзсан, эсхүл захиалагч хохирол барагдуулахыг шаардсан;
4. худалдан авах гэрээний үүргээ гүйцэтгэхэд мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эсхүл эрх бүхий бусад этгээд тогтоосон;
5. энэ хуулийн 10.9-д зааснаар, эсхүл давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг зохих ёсоор оролцуулаагүй, эсхүл давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй.



Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын байцаагчийн саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор аж ахуй эрхлэгчийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад гурван жилийн хугацаагаар бүртгэх шийдвэрийг гаргана.

ДОЛДУГААР БҮЛЭГ.

**ГОМДОЛ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ**



ЗАХИАЛАГЧ

Захиалагч тендер шалгаруулалттай холбоотой хуульд заасан үүргээ зөрчсөн гэж үзвэл сонирхогч этгээд, оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор



ШӨХТГ

тендер шалгаруулалтын баримт бичиг өрсөлдөөн хязгаарласан тухай сонирхогч этгээдийн үндэслэл бүхий гомдлыг тендерийн нээлтээс нээлттэй тендер шалгаруулалтын хувьд ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө, бусад аргын хувьд ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө



САНГИЙН ЯАМ

Захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлыг уг шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор, захиалагчид гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй тухай гомдлыг энэ хуулийн 57.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш ажлын 5 өдрийн дотор



ШҮҮХ

- Сонирхогч этгээд, эсхүл оролцогч гомдол хянан шийдвэрлэх байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл;
- худалдан авах гэрээ байгуулснаас хойш



ШӨХТГ, Сангийн яам гомдол хянан шийдвэрлэхэд:

- Гомдол хянан шийдвэрлэж дуусах хүртэл хугацаанд захиалагчийг үйлдэл хийхгүй байхыг даалгах, захиалагчийн шийдвэрийг түдгэлзүүлэх шийдвэр гаргана.
- Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана.
- Гомдол хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор гомдлын үндэслэлийн хүрээнд хянан шийдвэрлэнэ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай:



- **112.6.Шүүх Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан цахим системд байршуулсан баримт бичгээс бусад нотлох баримт гаргуулах, эсхүл цахим систем дэх баримт бичгийн үнэн зөвийг нотлох нэмэлт нотлох баримт цуглуулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 112.4.2-т заасан маргааныг хянан шийдвэрлэх хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.**
- **112.10.Шүүх энэ зүйлийн 112.4.2-т заасан маргааныг хянан шийдвэрлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан цахим системээс нотлох баримтыг цахимаар авч шинжлэн судлах ба захиалагч болон бусад этгээд тоон гарын үсгээр баталгаажуулж цахим системд байршуулсан баримт бичгийг нотлох баримтын шаардлага хангасанд тооцно.**

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай:



- 112.11.Энэ зүйлийн 112.4.2-т заасан маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг энэ хуулийн 80.2-т заасан үндэслэл болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар хойшлуулах бол дараагийн шүүх хуралдааны товыг хэргийн оролцогчдын саналыг харгалзан тогтоож, нэгээс илүүгүй удаа хойшлуулна.
- 113.7.Шүүх энэ хуулийн 112.4.2-т заасан маргааныг хянан шийдвэрлээд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн **41 дүгээр зүйлд зааснаар гэрээ илт хууль бус болохыг тогтоосон** бол гэрээний үүргийн гүйцэтгэлийг буцаах, эсхүл тэр даруй зогсоох нь нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол гэрээ эрх зүйн үйлчлэлгүй болох хугацаа, журмыг зохигчдын саналыг харгалзан тогтооно.

НАЙМДУГААР БҮЛЭГ.

БУСАД



ХАРИУЦЛАГА НОГДУУЛАХ

- ❖ Гэмт хэргийн шинжгүй бол төрийн албаны тухай болон хөдөлмөрийн тухай хуулиар хариуцлага тооцно.
- ❖ Ажилтан, албан хаагчид хуульд заасан хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг хүчингүй болгоно.
- ❖ Хуульд заасан хугацаанд шийдвэр гаргаагүй бол буруутай этгээд оролцогчдын тендер шалгаруулалтад оролцохтой холбогдсон бодит зардлыг төлнө.



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохоос **ӨМНӨ ЗАРЛАСАН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫГ** 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж дуусгана.

2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ ХҮЧИНТЭЙ** хэвээр байна.



САНГИЙН ЯАМ